

**МОНГОЛ УЛС ДАХЬ ТӨРИЙН  
ӨМЧ ХУВЬЧЛАЛЫН ТУХАЙ****Л. Дондог\***

Монгол Улс зах зээлийн харилцааг төлөвшүүлэх шилжилтийн явцдаа олон арван хүнд асуудалтай тулж байсан бөгөөд түүнээс хамгийн ярвигтай нь өмч хувьчлалын асуудал байлаа.

Өмч хувьчлалын арга хэлбэрийн асуудлаар 1990 оны хавраас эхлэн бараг бүтэн жил маргалдсаны эцэст 1991 оны 5 дугаар сард “Өмч хувьчлах тухай” хууль гарав. Маргааны эх үүсвэр нь нэг талаас хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр /ХОЭБ төрийн өмчийг хувьчлах, нөгөө талаас төрийн өмчийг хувь хүн, хамт олонд бэлэн мөнгө ба зээлээр худалдах, үнэгүй олгох, зарим хэсгийг ХОЭБ-ээр хувьчлах зэрэг аргуудыг хослон хэрэглэх гэсэн хоёр үзэл баримтлалыг ард нийтээр шүүн хэлэлцсэнд оршино. Эцэстээ ХОЭБ-ээр хувьчлах шийдвэрийг Улсын Бага Хурал гаргасан. Ингээд хууль гарах өдөр байсан Монгол Улсын иргэн бүрт төрийн өмчөөс 10 мянган төгрөгийн өмч эзэмших ХОЭБ-ийг тараасан юм. ХОЭБ нь 2 хэсэгтэй бөгөөд 7,0 мянган төгрөгийн баримжаа үнэтэй хэсэг нь их хувьчлалд буюу улсын томоохон үйлдвэрүүдийг хувьчлахад хөрөнгө оруулагчаар оролцоход ашиглах, 3 мянган төгрөгийн үнэтэй хэсгийг бага хувьчлалд буюу үйлдвэрлэл, үйлчилгээний жижиг объектуудыг худалдан авахад ашиглах зориулалттай байлаа.

Анх төрийн өмчид хамаарах хөрөнгийн 44,2% буюу 22 тэрбум төгрөгийн /1991 оны үнээр хөрөнгийг хувьчлахаар тооцоолсон. Үүнээс хойш хүн амд 19,9 тэрбум төгрөгийн нэрлэсэн өртөг бүхий 1989,9 мянган ширхэг ХОЭБ тараасан. Одоо өмч хувьчлалын төв, орон нутгийн комиссууд 17,6 тэрбум төгрөгийн хөрөнгө хувьчлах шийдвэр гаргасны 13,7 тэрбум нь их хувьчлалд, 3,9 тэрбум нь бага хувьчлалд хамаарч байна. Үүнээс 368 компанийн 8,3 тэрбум төгрөгийн хувьцаа Монголын хөрөнгийн биржээр дамжин арилжаалагдаад байна. 1993 оны 10 дугаар сараас ХОЭБ тараах ажлыг зогсоосон, 1994 оны 9 дүгээр сараас өмнө дээр тараагдсан ХОЭБ-ийг өмч хувьчлалд оруулах явдал чухал байгаа юм. Гэхдээ тараагдсан 2 тэрбум төгрөгийн бага хувьчлалын эрхийн бичиг хөрөнгийн баталгаагүй байгаа нь анхаарал татах асуудал мөн.

Төрийн өмч оролцсон, түүний дотор давамгайл байдлаар оролцсон хувьцаат компаниудын жагсаалтыг Засгийн газар баталсан. Хувьцаат компаниудын хувьцааг ХОЭБ-ээр арилжаалах ажлыг Монголын жарангийн бирж гүйцэтгэж байна.

\*Л. Дондог - ШУА-ийн Эдийн засгийн хүрээлэнгийн захирал, дэд доктор

Бага хувьчлалаар объект авах хувь хүн, хамт олон ягаан тасалбарыг бирж болон хар захаас худалдан авч цуглуулдаг байв. Хувь хүн, хамт олжн уг ажлын байрыг түрээсийн гэрээгээр эзэмшиж байсан бол өмч хувьчлалын комиссын үнэлсэн үнийн дүнтэй тэнцэх ягаан тасалбар цуглуулж төлөөд хувьчлагдсан зүйлээ авдаг байв. Харин түрээсийн гэрээгүй бол дуудлагын худалдаанд оруулж сонирхогчид үнэ хаялцах худалдан авах гэрээ байгуулаад, тогтоосон хоногт багтаан ягаан тасалбарыг нь олж төлдөг байв. Ингэж улсын өмчийг авсан хувь хүн ба хамт оюн өөрсдийн тааламжаар аж ахуйн аль нэгэн нэгж байгуулдаг байв. Одоо төрийн өмчийг хувьчилж авсан 624 хувьцаат компани, 748 ББХК, 1632 ББХХ, 48 БХХ, 786 ХЭАА бий болжээ. Одоо үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүний 45%, худалдаа үйлчилгээний бараг 100% хувьчлагдсан болон хувийн секторт ногдож, мал сүргийн 90 шахам хувь нь хувийн өмчид шилжжээ.

#### Өмч хувьчлалын арга

Төрийн өмчийг ХОЭБ-ээр хувьчлах аргыг сонгож авахад тодорхой хүчин зүйл нөлөөлсөн юм. Үүнд:

-«төрийн өмч нь нийт ард түмний өмч мөн тул түүнийг нийтээр тэгш хувааж авах ёстой гэсэн ойлголттой хүмүүс их байсан;

-«тодорхой үед тодорхой объектийг худалдаад авах хэмжээний мөнгөтэй хүн цөөн байсан;

-зах зээлийн харилцааны талаар мэдлэг сул байсан;

-өмч хувьчлалыг хамгийн хурдан явуулахад энэ арга тохиромжтой байсан;

-энэ аргаар хийхийн улс төрийн зарим хүчнүүд эрчимтэй шахаж шаардаж байсан зэрэг болно.

ХОЭБ-ийг ашигласны гол эерэг тал нь нэгдүгээрт, хуримтлалгүй, мөнгөгүй хүн амд төрийн өмчийг тэгш хуваасан нь ямар нэгэн мөргөлдөөн, зөрчил, тэмцэлд хүргээгүй; хоёрдугаарт, өмч хувьчлалыг хурдан явуулахад чухал нөлөө үзүүлсэнд оршино. Энэ арга хэрэглэсний сөрөг тал нь:

1. Төрийн өмчийг хувьчлах бусад олон арга хэрэглэх замыг хаасан. Тухайлбал улсын томоохон үйлдвэрийн газрыг гадаадын болон Монгол Улсын ямар ч иргэн худалдаж авах боломжгүй болгосон.

2. Урьд нь улсын үйлдвэрийн газрын дарга яамны сайдаас эмээдэг байжээ. Гэтэл одоо 20; 30; 40 мянган хувьцаа эзэмшигчтэй компанийн дарга өмчийн эзэн мэт харагдах боллоо. Хувьцаат

компанийн ажил цалгардах, үр ашиг буурах талаар хяналт тавьдаг эзэн үгүй болжээ. Хувьцаат компанийн хөрөнгийг хэрхэх зарцуулах нь дэлхын дурын хэрэг болжээ. Ингэж өмч эзэнгүй боллоо. Үнэт цаасны, хоёрдогч зах зээл ажилд орсноор ийм байдал арилах мэтээр арьдаг хүмүүс их бий. Энэ тийм ч хялбар цэгцрэхгүй байж болох талтай. Учир нь хувьцааны хяналтын багц нэг гарт бөөгнөрөх явц компани бүрд харилцан адилгүй хугацаа зарцуулагдана. Зарим компанийн хувьцааны гүйлгээ сайн байх нь ойлгомжтой. Манай өнөөгийн нөхцөлд ашиг өгөх эсэх нь мэдэгдэхгүй хувьцаа авч мөнгөө түгжсэнээс гүйлгээний хүрээнд эргүүлж ашиг олох гэсэн сонирхолтой хүмүүс их байдаг. Ингээд бодоход олон зуун хувьцаат компанийн өмч эзэнгүй хэвээр олон жил үргэлжилж магадгүй төлөвтэй. Энэ бол нийт эдийн засагт зохисгүй нөлөөтэй юм.

3. Төрийн өмчийг үнэгүй хувьчлах нь залыт этгээдүүд хуйвалдан хөрөнгө завших нөхцөл бүрдүүлдэг ажээ. Өмч хөрөнгөтэй олон хүн ямар нэгэн аргаар хувьдаа авч завших гэсэн сэтгэлгээтэй болж бүх шатанд хяналт суларч, өмчийн хулгай ихэссэн юм.

4. Бага хувьчлалын эрхийн бичиг гүйлгээнд орох үед бэл чинээтэй хүмүүст хадгалагдаж байсан мөнгө олон түмэнд цацагдсан нь менений инфляцийг түргэтгэхэд нөлөө үзүүлэв. Дэлхийн олон орны туршлагаас үзэхэд төрийн өмч хувьчилснаар хүмүүсийн гар дээрх бэлэн мөнгө төрийн гарт татагддаг бол манайд энэ үйл явц хэрэгжсэнгүй. Өөрөөр хэлбэл өмч хувьчилснаар улсын төсвийн алдагдлыг нөхөх буюу эсвэл төр хөрөнгө оруулалтад зориулах хөрөнгийн эх үүсвэртэй болж чадсангүй.

ХОЭБ-ийг 200 төгрөгийн үнэтэй тараасан бөгөөд түүний орлого дээр бага хувьчлалаас орсон бага зэргийн мөнгө нийлээд 500 гаруй сая төгрөгөөр өмч хувьчлалын сан бүрджээ. ХОЭБ-50%, бага хувьчлал 40%. Энэ сангийн 30% нь Монголын хөрөнгийн бирж, брокерийн пүүсүүдийг санхүүжүүлэх, 44% нь хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдэд зээл олгоход зориулагджээ. Гэхдээ олгосон зээл нь ч тэр бүр үр дүнтэй арга хэмжээ болж чадаагүй, зарим нь буцаж төлөгдөх найдваргүй болсон гэсэн мэдээ бий.

5. Эрх зүйн баримт бичгүүдэд хувьчлагдаж байгаа улсын үйлдвэрт ажиллагчид хувьцааг нэрлэсэн үнээр нь авах давуу эрх эдлэхээр тусгагдсан юм. Энэ нь тухайн хүн 7000 төгрөгийн эрхийн бичигт 100 төгрөгийн нэрлэсэн өртөгтэй 70 ширхэг хувьцаа авах боломжийг өгүүлсэн хэрэг юм. Бирж дээр хувьцааг эрхийн бичгээр солиод бодит ханш нь нэрлэсэн өртгөөс өссөн тохиолдолд давуу эрх хангагдаж байна. Харин эсрэг тохиолдолд байдлыг хүндрүүлж байгаа юм. Тухайлбал, "А" гэдэг компанид ажиллагч давуу эрхээ эдэх биржид хувьцаа борлогдохоос өмнө 70 ширхэг хувьцаа авчээ. Гэтэл 100 төгрөгийн нэрлэсэн өртөгтэй хувьцааны бодит ханш унаад 10 төгрөг

болсон үед тэнд ажилладаггүй гаднын хүн 700 ширхэг хувьцаа авах болно. Ингэж “давуу эрх” гэгч нь зарим тохиолдолд зөрчигдлөө.

#### Өмч хувьчлалын зохион байгуулалт

Төрийн өмч хувьчлалын ажлыг Засгийн газрын өмч хувьчлалын комисс ерөнхийд нь зохион байгуулсан юм. Аймаг, хотын захиргаадад мөн өмч хувьчлалын комисс ажиллав. Төв комиссыг Засгийн газрын тэргүүн шадар сайд, орон нутгийн комиссыг Засаг даргын орлогчид толгойлж байв.

Засгийн газраас олон арван дүрэм, журам, заавар гаргаж, мөрдүүлэв.

Засгийн газрын комисс орон нутгийн комиссуудыг шууд удирдаж байв. 1991 оны 7 дугаар сарын 1-ний байдлаар төрийн өмчид тооллого хийж, үүнээс хойшхи хөрөнгийн хөрөнгийг хянаж байлаа. Гэхдээ энэхүү тооллогоос өмнө улсын хөрөнгийг худалдах, завших, хулгайлах талаар зальт этгээдүүд их зүйл амжуулсан байлаа. Үүнийг засаж залруулах талаар одоо хүртэл дорвитой ажил зохиогоогүй байна. Өмч хувьчлалын төв ба орон нутгийн комиссууд уг ажилд оролцогчдод сургалт явуулах, туршлага судлуулах, зөвлөлгөөн хийх, орон нутагт өмч хувьчлалын хөтөлбөр хийх, түүнийг хянаж батлах зэрэг үлэмж их ажил хийснийг тэмдэглэвэл зохино.

Төрийн өмч хувьчлалыг салбар тус бүрийн онцлогийг харгалзан өвөрмөц байдлаар зохион байгуулжээ.

1.Худалдаа, ахуй үйлчилгээний газар, нэгжүүд, зарим жижиг цехүүдийг шууд бага хувьчлалд оруулж, тодорхой нэг буюу хэсэг хүмүүст ХОЭБ-ээр худалдав.

2.Улсын том үйлдвэрийн газруудын хөрөнгөд дахин үнэлэлт хийсний дараа тухайн газарт технологийн шууд холбогдолгүй цех, нэгж хэсгийг салгаж бага хувьчлалд оруулан худалдаад үлдсэн гол хэсгийг улсын үйлдвэрийн газар ба хувьцаат компани хэлбэрээр зохион байгуулжээ.

3. Сангийн аж ахуй, тэжээлийн аж ахуйд бас арай өөр байдлаар хандав. Энд 2 сангийн аж ахуйгаар жишээлж яривал арай ойлгомжтой болох биз ээ. Мал аж ахуй бүхий Архангай аймгийн Түвшрүүлэхийн сангийн аж ахуй сумын хэмжээний 4000 хүнд тус бүрд 3 бог мал, харин малчин өрхийн ам тус бүрд 4 бог малаар тооцож нийт малынхаа 30 хувийг ХОЭБ-ээр тарааж, үлдсэн мал, бусад хөрөнгийг эзэмшсэн улсын өмч давамгайлсан хувьцаат компани зохион байгуулжээ.

Төв аймгийн “Октябрь” сангийн аж ахуй бага хувьчлалаар малын 40 орчим хувь, ихэнх орон сууц, зарим машин техникийг ХОЭБ-ээр худалдаад үлдсэн буурин дээр нь доорхи төрийн өмч давамгайлсан хувьцаат компаниуд үүсчээ. Үүнд:

-тус бүр төмс, хүнсний ногооны 270 га үр тарианы 1300 га талбайтай, 2000 орчим толгой мал, түүнд тохирсон бэлчээртэй 3 хувьцаат компани;

-саалийн механикжсан ферм, бэлчээр, хадлан, тэжээл тариалах талбай, техникийн салаа бүхий хувьцаат компани;

-хөдөө аж ахуйн машины төв парк, засварын газар, үрийн төмсний агуулах, үтрэм бүхий хувьцаат компани.

Ингэж тухайн сангийн аж ахуй 5 аж ахуйн нэгж болон задарчээ.

Өмч хувьчлалын зохион байгуулалт үйл ажиллагаанд бага бус алдаа дутагдал оршиж байв

1. Өмч хувьчлалын ажлыг олон түмний хяналтын доор явуулаагүй. Аль ч өмч хувьчлалын комиссийн дэргэд олон түмний хяналтын зөвлөл, комисс байгуулсангүй. Ийм хяналтгүйгээс дунд тушаалтнуудад төрийн өмчийг завших бололцоо олгох, янз бүрийн зөрчилт будлиан гарах нөхцлийг бүрдүүлж өгсөн юм. Нийслэлийн өмч хувьчлалын комисс 1992 онд “Арьс импекс” зэрэг 63 аж ахуйн нэгж, газрын эд хөрөнгийг шалгаж, хурлаараа хэлэлцэхгүйгээр, албан бичгээр хувьчилж байжээ. Мөн нийслэлийн Худалдаа, нийтийн хоолны салбараас бусад салбарын бага хувьчлалаар хувьчлагдсан цох, тасаг, үйлдвэрийн ажлын байрны ихэнхийг түрээсийн гэрээгүй байхад нь дуудлагын худалдаанд оруулахгүйгээр “Хамт олны давуу эрх” гэдэг жуулинд байхгүй нэрээр анхных нь үнээр олгосон байна.

Дуудлагын худалдаагаар авсан эд хөрөнгийн үнийг хуульд заасан хугацаанд нь төлөөгүй байхад нь хугацааг дур мэдэн сунгах, эрхийн бичгийг дутуу хагас тоолж авах зэрэг дутагдал илэрч байлаа. Наад зарим зөрчлийг дурдахад ийм байна. Энэ бол олон түмний хяналт дутагдсантай холбоотой.

2. Өвч хувьчлалын комисс төрийн өмчийг хувьчлах үүрэг гүйцэтгэсэн болохоос биш, төрийн өмчийн талаар бодлого боловсруулж хэрэгжүүлсэнгүй. Өөрөөр хэлбэл, өнгөрсөн хугацаанд төрийн өмчийн талаар бодлого явуулах, түүний ашиглалт, хамгаалалтад хяналт тавих газар байсангүй. Иймээс төрийн өмчид эзэн хүний хяналт дутагдах, улсын үйлдвэрийн газрын дарга нар янз бүрийн газарт их хэмжээний хандив өргөж, бараа түүхий эд, үндсэн хөрөнгийг үнэ хямдруулан худалдаж байлаа. Төрийн өмчийн ба төрийн өмч оролцсон компанийн удирдлагыг томилох, тэдний ажлын тайланг сонсох,

хувьцааны хэдэн хувийг төрийн ямар байгууллага хэрхэн барьж байх, ногдол ашгийг хэрхэн татаж авах, өргөтгөл шинэтгэл хийх эх үүсвэрийг явж гаргах гэх мэт олон асуудлыг урсгалд нь явуулж ирлээ.

3. Өмч хувьчилж авсан хүмүүстэй цаашдын үйл ажилагааны талаар нарийн тохиролцож гэрээ байгуулж, түүндээ хяналт тавьж ажиллаагүй. Иймээс олон түмэнд үйлчлэх үүргээ зарим аж ахуйн нэгжүүд гэнэт өөрчлөх буюу зарим дэлгүүрийн эзэд аж ахуйгаа эрхэлж чадахгүй, дампуурлийн байдалд орж, хүн амын хэрэгцээг гачигдуулж байв.

4. Нилээд олон газрыг хувьчлахдаа гадаад дотоодын байгууллагатай хийх тооцооны үлдэгдлийг баталгаажуулаагүй, зөвхөн дансанд бичигдсэн тоог баримталж байжээ. Үүний цаана хэдий хэмжээний хөрөнгө үрэгдсэн нь тодорхойгүй байна.

5. Хувьчлалын явцад зарим улсын үйлдвэрийн газар хэт жижигрэн салж, зарим нь бүр технологийн дамжлагаар салж бие даасан компаниуд болсоноос ажлын уялдаа алдагдаж байлаа. Мөн зарим нь хувьчлагдсаны дараа технологийн чухал хэрэгцээт машин тоног төхөөрөмжийг ч зарж борлуулах явдал гарлаа. Дорнод, Архангай аймгийн барилга угсралтын байгууллага, Угсармал барилга үйлдвэрлэлийн автомашин механизмийн “Хөсөг” компани, “Отгонтэнгэр”, “Гурваннуур”, “Улаанбаатар”, “Хүрд”, “Монинж-Бар” зэрэг барилгын компаниудад ийм зөрчил илрэв.

Газар тариалан эрхэлдэг улсын сангийн аж ахуйнууд олон хэсэг болж задрав. Хуучин Баянцогтын сангийн аж ахуй 32 аж ахуйн нэгж болон задарчээ. Урьд нь 18 сангийн аж ахуйтай байсан Сэлэнгэ аймаг 95 жижиг аж ахуйн нэгжтэй болсон байв. Үүнээс болж нэг нь үр тарианы үтрэмтэй нөгөө нь хоосон, нэг нь агуулахтай, нөгөөд нь юу ч байхгүй байх зэргээр технологийн уялдаа алдагдаж үйлдвэрлэл явуулах боломжгүйд хүрч байлаа. Энэ байдлыг одоо засах гэж оролдож байна.

Өмч хувьчлалын дүнд хуучин улсын монополь, хувийн монополиор эв зүйгээ олж чадсангүй. Хувийн монопольт компаниуд үйлдвэрлэл нь буураад байхад, бүтээгдхүүнийхээ үнийг хэд дахин нэмж, ашиг олж, ажилчдын цалинч уралдан нэмж, хувьцаа эзэмшигчиддээ ахиу ногдол ашиг өгч, дарга нар нь нэр хүнд олж авахын төлөө тэмцэж байна. Энэ нь эцэстээ ард түмний амьдралд бэрхшээл учруулж байна.

Дээр өгүүлсэн алдаа дутагдал бол төрийн өмч хувьчлалын ажлыг бүхэлд нь хараар будаж чадахгүй юм. Өмч хувьчлалын гол үр дүн нь: нэгдүгээрт, төрийн өмчийн ноёрхол задарч, олон өмчийн хэлбэрт

тогтолцоо бүрэлдэн тогтсон; хоёрдугаарт, зах зээлийн харилцаанд шилжих үйл явцыг эргэлт буцалтгүй болгох баталгаажуулсан; гуравдугаарт, хүн амд зах зээлийн тухай ойлголтыг бодитойгоор тэрүүлж, хүмүүсийн сэтгэлгээг өөрчилсөн байгаад оршино.

Өмч хувьчлалын явцад маш олон асуудлыг зүй зохистой шийдвэрлэж байсны дотор Монголын хөрөнгийн биржийн тогтолцоог бүрдүүлсэн явдал маш чухал ололт гэж үзвэл зохистой.

Төрийн өмч хувьчлалтын явцад Монгол улсын иргэн бүрийг хувийн өмчтөн болгохыг эрмэлзсэн нь нэн сайшаалтай юм. Ялангуяа хөдөөгийн хүн ам, түүний дотор малчин өрхүүд хэдэн арав, зуугаад зоологдох толгой мал хувьчилж авсандаа тун сэтгэл хангалуун байдаг.

Жижиг худалдаа, үйлчилгээний газруудыг ганцаар болон хамтаар өмчилсэн хүмүүс ч их буюу бага ямар нэгэн ашиг хувааж авчээ.

Өмч хувьчлалын ажил цаашид тасралтгүй үргэлжлэх үйл явц юм. Өнгөрсөн 2 жил гаруйн туршлага, сургамж бидэнд их мэдлэг, дадлага өгсөн. Үүнд тулгуурлаад урьдын алдаа дутагдлыг засаж залруулж ажиллах нь зүйн хэрэг юм.

Ойрын үед бодож анхаарвал зохих, дараах цөөн зүйл байна.

1. Өмч хувьчлалын эхний шатны ажил эхэлнэ. Энэ онд дуусч дараагийн шатны ажил эхэлнэ. Өөрөөр хэлбэл Үнэт цаасны хоёр дахь зах зээд ажиллаж эхэлнэ. Энэ нь дээр өгүүлсэн гажуудлыг засахад их ач холбогдолтой хэмээн зарим хүмүүс үзэж байгаа. Түүнтэй би санаа нэг байдаг. Гэхдээ дахиад эдийн засгийг эрүүлжүүлэх бус харин, сулруулах нөлөө үзүүлж болзошгүй нэг тал бий. Энэ нь компаниудын хувьцаа хүмүүсийн хооронд арилжаалагдах үед том капиталтнуудын гарт хуримтлагдсан мөнгө нийт ард түмэнд тарж эхэлнэ. Энэ бол дахиад инфляцийг хурдасгах нөхцөл, болж өгнө. Эсвэл тийм том капиталтан байхгүй бол үнэт цаасны хоёр дахь зах зээл авиагүй болно. Иймд энэ асуудлыг маш сайн бодох, зохицуулах ёстой.

2. Энэ удаагийн хувьсгалд хамраагүй байгаа цахилгаан, эрчим хүч, нефть хангамж, уул уурхай, зам, холбоо, нийтийн тээвэр, гадаад худалдаа, банк, санхүү зэрэг салбарыг хувьчлахад ХОЭБ-ийн аргыг хэрэглэхгүй байх нь зүйтэй. Хувьцааг компани болговор хувьцааг нь шууд мөнгөөр худалдах зэрэг бусад олон аргыг хэрэглэвэл зохино.

3. Орон сууцны хувьчлал маш эмзэг асуудал бөгөөд бас хүн амын дотор 2 тэрбум орчим төгрөгийн үнэ бүхий ягаан тасалбар үлдсэн зэргийг бодолцвол зохино.

4. Цаашид хамгийн их анхаарвал зохих зүйл бол хувьчлагдсан үйлдвэрийн газруудын дотоод харилцаа, менежментийн доголдол

мөн. Энэ талаар сургалт явуулах, туршлага судлуулах, зөвлөгөө өгүүлэх, эрдэм шинжилгээний ажил явуулах зэрэг их ажил бий. Өмч хувьчлалын сангийн хөрөнгийг бусдад зээлдүүлэхийн оронд ийм арга хэмжээнд зориулж байсан бол илүү үр дүнтэй байж магадгүй билээ.

Хувьцаат компани болон бусад хувьчлагдсан аж ахуйн нэгжүүдийн байдлыг төр хараа хяналтаасаа гаргаж орхимгүй байна. Тэдгээртэй ажилладах, дэмжиж туслан, зөвлөдөг зохион байгуулалтын бүтцийг бий болгох нь зүйтэй.

БАРИМТ БИЧИГ,  
ЛАВЛАХ

**“МОНГОЛ УЛСЫН ГАДААД БОДЛОГО  
1990-ЭЭД ОНД” ОНОЛ ПРАКТИКИЙН  
БАГА ХУРЛЫН ЗӨВЛӨМЖ**

Бага хурал 1994 оны 6 дугаар сарын 20-21-ний өдрүүдэд болж, гадаад харилцаанд оролцогч төр, засаг, олон нийтийн байгууллагуудын төлөөлөгчид, дипломатууд оролцов.

Бага хурлаас доорх зөвлөмжийг гаргав. Үүнд:

**1. Гадаад бодлогын үзэл баримтлалыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд анхаарах бодлогын чанартай зарим асуудал**

1. Гадаад бодлогын үйл ажиллагааны шинжлэх ухааны үндэслэлийг сайжруулах, энэ зорилгоор гадаад харилцааны болон шинжилгээ, судалгааны байгууллагуудын ажлын хэлхээ холбоог оновчтой болгох.

2. Манай улсын эдийн засгийн аюулгүй байдлын үзэл баримтлалыг боловсруулж, хэрэгжүүлэх,

3. Дипломат албаны тухай хуулийг боловсруулж гаргуулах,

4. Үндэснийхээ аюулгүй байдлыг улс төрийн аргаар бүх талаас нь хангах хэрэгт НҮБ-ын боломжийг оновчтой ашиглах талаар санал зөвлөмж боловсруулах.

5. Ази, Номхон далайн бүс нутгийн гол улс орнуудтай хоёр талын харилцаа, түүний дотор худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар бүсийн орнуудын олон талын хамтын ажиллагаанд анхаарлаа чиглүүлэх.

6. Эх орныхоо байгалийн өвөрмөц онцлогийг хөгжлийн зорилгод ашиглах, дэлхийн байгаль орчны тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд дөхөм болгох зорилгоор НҮБ-ын хүрээлэн буй орчны хөтөлбөртэй хамтран ажиллах. Шим ертөнцийн удмын сангийн чухал